



МОНГОЛЫН  
ХӨРӨНГИЙН  
БИРЖ

# 2017

## Э-сонин

8-Р САР

53-р дугаар






## Зах зээлийн тойм


/2017.08.31-ний өдрийн байдлаар/

|                                             |                          |
|---------------------------------------------|--------------------------|
| <b>1. Арилжаа явагдсан өдөр</b>             | <b>23</b>                |
| <b>2. Нийт арилжааны үнийн дүн /төгрөг/</b> | <b>66,165,174,545.35</b> |
| Хувьцаа                                     | 4,427,864,154.35         |
| Засгийн газрын үнэт цаас /анхдагч/          | 52,233,533,591           |
| Засгийн газрын үнэт цаас /хоёрдогч/         | 9,503,776,800            |
| Компанийн бонд /анхдагч/                    | 0                        |
| Компанийн бонд /хоёрдогч/                   | 0                        |
| <b>3. Нийт арилжигдсан үнэт цаасны тоо</b>  | <b>4,438,715</b>         |
| Хувьцаа                                     | 3,794,738                |
| Засгийн газрын үнэт цаас /анхдагч/          | 547,237                  |
| Засгийн газрын үнэт цаас /хоёрдогч/         | 96,740                   |
| Компанийн бонд /анхдагч/                    | 0                        |
| Компанийн бонд /хоёрдогч/                   | 0                        |
| <b>4. Нийт хийгдсэн хэлцлийн тоо</b>        | <b>2,965</b>             |


## Зах зээлийн үнэлгээ



## MSE ALL индекс



## TOP-20 индекс



## Бүртгэлтэй хувьцаат компани

|                              |            |
|------------------------------|------------|
| <b>1. Нийт компанийн тоо</b> | <b>220</b> |
| 100% төрийн өмчит            | 19         |
| Төрийн өмчийн оролцоотой     | 12         |
| Хувийн өмчийн                | 189        |
| I ангилал                    | 7          |
| II ангилал                   | 45         |
| III ангилал                  | 167        |
| Ангилалдаагүй                | 1          |

## Гишүүн үнэт цаасны компани

|                                            |           |
|--------------------------------------------|-----------|
| <b>1. Гишүүн Үнэт цаасны компанийн тоо</b> | <b>58</b> |
| Брокер, Дилер                              | 58        |
| Андеррайтер                                | 24        |
| Хөрөнгө оруулалтын зөвлөх                  | 14        |



# Үнэт цаасны зах зээл

## Арилжаанд идэвхтэй оролцсон үнэт цаасны компаниуд

/2017.08.31-ний байдлаар/

| Симб<br>ол | Нэр                              | Үнэт цаас авсан |                  | Үнэт цаас зарсан |                  | Арилжааны дүн /авсан,<br>зарсан/ (₮) |
|------------|----------------------------------|-----------------|------------------|------------------|------------------|--------------------------------------|
|            |                                  | Тоо ширхэг      | Үнийн дүн (₮)    | Тоо ширхэг       | Үнийн дүн (₮)    |                                      |
| 1          | БиДиСек ХК                       | 1,259,104       | 1,687,039,194.12 | 1,390,198        | 1,939,111,896.15 | 3,626,151,090.27                     |
| 2          | Голомт Капитал ХХК               | 525,765         | 185,899,198.66   | 922,873          | 383,762,478.45   | 569,661,677.11                       |
| 3          | Стандарт инвестмент ХХК          | 167,828         | 174,188,750.62   | 363,873          | 140,098,693.80   | 314,287,444.42                       |
| 4          | Ард капитал групп ХХК            | 596,067         | 269,423,828.40   | 55,030           | 24,823,431.50    | 294,247,259.90                       |
| 5          | Бумбат-Алтай ХХК                 | 279,845         | 184,503,302.10   | 154,903          | 107,067,178.50   | 291,570,480.60                       |
| 6          | Ти Ди Би Капитал ХХК             | 220,686         | 123,651,731.30   | 181,668          | 93,756,639.46    | 217,408,370.76                       |
| 7          | Новел инвестмент ХХК             | 219,956         | 185,078,117.70   | 10,437           | 8,505,600.00     | 193,583,717.70                       |
| 8          | Блүмсбюри секюритиес ХХК         | 42,866          | 27,505,455.00    | 98,388           | 58,094,942.00    | 85,600,397.00                        |
| 9          | Эм Ай Си Си ХХК                  | 51,623          | 77,771,130.00    | 900              | 432,000.00       | 78,203,130.00                        |
| 10         | Ард секюритиз ХХК                | 79,520          | 51,973,680.93    | 33,101           | 12,053,255.50    | 64,026,936.43                        |
| 11         | Тулгат чандмань баян ХХК         | 9,101           | 20,910,490.15    | 19,312           | 42,208,550.15    | 63,119,040.30                        |
| 12         | Гаули ХХК                        | 101,692         | 33,594,636.70    | 28,374           | 28,079,282.00    | 61,673,918.70                        |
| 13         | Монсек ХХК                       | 43,177          | 25,162,237.00    | 44,142           | 31,694,009.00    | 56,856,246.00                        |
| 14         | Тэсо Инвестмент                  | 31,588          | 17,136,262.03    | 110,465          | 35,079,077.00    | 52,215,339.03                        |
| 15         | Мирэ Эссет Секьюритис Монгол ХХК | 721             | 6,425,700.00     | 6,678            | 45,380,700.00    | 51,806,400.00                        |
| 16         | Таван богд ХХК                   | 1,090           | 10,851,600.00    | 2,739            | 37,676,055.00    | 48,527,655.00                        |
| 17         | Санар ХХК                        | 10,137          | 3,610,030.00     | 101,715          | 42,795,293.00    | 46,405,323.00                        |
| 18         | Эм Ай Би Жи ХХК                  | 93,151          | 18,201,060.00    | 125,358          | 22,099,916.00    | 40,300,976.00                        |
| 19         | Лайфтайм инвестмент ХХК          | 2,722           | 15,282,200.00    | 2,911            | 20,391,560.00    | 35,673,760.00                        |
| 20         | Зэргэд ХХК                       | 5,386           | 7,444,189.00     | 33,341           | 22,332,445.00    | 29,776,634.00                        |

## Идэвхтэй арилжигдсан хувьцаа

/2017.08.31-ний байдлаар/

| №  | Сим-<br>бол | Үнэт цаасны нэр              | Арилжсан ширхэг | Үнийн дүн /₮/    | Дээд     | Доод     | Хаалт    | Өөрчлөлт<br>/Нэгж/ | Өөрчлөлт<br>/%/ |
|----|-------------|------------------------------|-----------------|------------------|----------|----------|----------|--------------------|-----------------|
| 1  | APU         | АПУ                          | 1,785,845       | 756,025,112.20   | 498.00   | 355.10   | 451.92   | 65.26              | 16.88           |
| 2  | SHV         | ШИВЭЭ ОВОО                   | 692,075         | 1,402,971,764.00 | 2,500.00 | 2,005.00 | 2,100.00 | 60.00              | 2.94            |
| 3  | SUU         | СҮҮ                          | 539,744         | 87,811,654.40    | 170.00   | 140.00   | 160.39   | 22.97              | 16.72           |
| 4  | JTB         | ЖЕНКО ТУР БЮРО               | 186,071         | 11,445,675.24    | 68.00    | 58.00    | 58.65    | -11.35             | -16.21          |
| 5  | RMC         | РЕМИКОН                      | 129,526         | 5,430,770.09     | 45.00    | 40.20    | 41.69    | -3.29              | -7.31           |
| 6  | HGN         | ХӨХ ГАН                      | 118,759         | 9,552,606.20     | 95.00    | 75.10    | 80.00    | -2.66              | -3.22           |
| 7  | TTL         | ТАВАН ТОЛГОЙ                 | 64,229          | 470,014,365.00   | 9,190.00 | 5,360.00 | 7,640.00 | 2,290.00           | 42.80           |
| 8  | MNP         | МОНГОЛ ШУУДАН ХК             | 41,159          | 15,833,958.00    | 388.00   | 383.00   | 385.02   | 2.02               | 0.53            |
| 9  | HRM         | ГЕРМЕС ЦЕНТР                 | 34,392          | 4,982,159.00     | 155.00   | 140.00   | 144.79   | 4.79               | 3.42            |
| 10 | UID         | УЛСЫН ИХ ДЭЛГҮҮР             | 30,909          | 15,424,615.00    | 520.00   | 473.00   | 500.00   | 29.00              | 6.16            |
| 11 | MDR         | ФРОНТИЕР ЛЭНД ГРУПП          | 24,580          | 9,217,220.00     | 375.00   | 374.00   | 375.00   | -0.05              | -0.01           |
| 12 | MMX         | МАХИМПЕКС                    | 18,481          | 44,340,485.00    | 2,500.00 | 2,380.00 | 2,400.00 | -49.00             | -2.00           |
| 13 | HBZ         | ХҮННУ МЕНЕЖМЕНТ              | 16,200          | 93,150.00        | 5.75     | 5.75     | 5.75     | 0.75               | 15.00           |
| 14 | BAN         | БАГАНУУР                     | 14,085          | 27,780,167.00    | 2,230.00 | 1,821.00 | 2,183.00 | 263.00             | 13.70           |
| 15 | HBO         | ХАЙ БИ ОЙЛ                   | 10,094          | 882,121.45       | 100.00   | 85.00    | 85.20    | -14.80             | -14.80          |
| 16 | MIB         | МОНИНЖБАР                    | 7,425           | 1,326,042.00     | 183.00   | 170.00   | 180.00   | 22.00              | 13.92           |
| 17 | SHG         | ШАРЫН ГОЛ                    | 7,410           | 16,633,783.00    | 2,530.00 | 2,130.00 | 2,439.00 | 303.00             | 14.19           |
| 18 | HRL         | ХЭРЛЭН ХИВС                  | 7,202           | 421,728.15       | 68.00    | 58.00    | 58.15    | -21.85             | -27.31          |
| 19 | BUK         | УБ-БУК                       | 7,194           | 3,258,242.00     | 488.10   | 425.00   | 488.01   | 63.01              | 14.83           |
| 20 | MCH         | МОНГОЛЫН ЦАХИЛГААН<br>ХОЛБОО | 6,780           | 3,549,025.00     | 569.00   | 500.00   | 540.00   | 49.00              | 9.98            |



## Ханшийн өсөлттэй хувьцаа

/2017.08.31-ний байдлаар/

| №  | Үнэт цаас нэр            | Арилжигдсан<br>Ширхэг/ | Хаалтын ханш |            | Ханшийн<br>өөрчлөлт /төгрөг/ | Өөрчлөлт /%/ |
|----|--------------------------|------------------------|--------------|------------|------------------------------|--------------|
|    |                          |                        | 2017-8-01    | 2017-08-31 |                              |              |
| 1  | ТАВАН ТОЛГОЙ             | 64,229                 | 5,350.00     | 7,640.00   | 2,290.00                     | 42.80        |
| 2  | БАЯНТЭЭГ                 | 15                     | 11,500.00    | 15,200.00  | 3,700.00                     | 32.17        |
| 3  | ЕВРОАЗИА КАПИТАЛ ХОЛДИНГ | 8                      | 64.65        | 83.00      | 18.35                        | 28.38        |
| 4  | МЕРЕКС                   | 1,559                  | 51.70        | 61.90      | 10.20                        | 19.73        |
| 5  | АПУ                      | 1,785,845              | 386.66       | 451.92     | 65.26                        | 16.88        |
| 6  | СҮҮ                      | 539,744                | 137.42       | 160.39     | 22.97                        | 16.72        |
| 7  | МОНГОЛ АЛТ               | 356                    | 6,170.00     | 7,200.00   | 1,030.00                     | 16.69        |
| 8  | АВТО ИМПЕКС              | 72                     | 2,400.00     | 2,780.00   | 380.00                       | 15.83        |
| 9  | ХАР ТАРВАГАТАЙ           | 202                    | 7,800.00     | 9,000.00   | 1,200.00                     | 15.38        |
| 10 | ХҮННУ МЕНЕЖМЕНТ          | 16,200                 | 5.00         | 5.75       | 0.75                         | 15.00        |
| 11 | ТАВИЛГА                  | 6                      | 1,200.00     | 1,380.00   | 180.00                       | 15.00        |
| 12 | УБ-БҮК                   | 7,194                  | 425.00       | 488.01     | 63.01                        | 14.83        |
| 13 | МОНГОЛ КЕРАМИК           | 3                      | 9,000.00     | 10,300.00  | 1,300.00                     | 14.44        |
| 14 | ШАРЫН ГОЛ                | 7,410                  | 2,136.00     | 2,439.00   | 303.00                       | 14.19        |
| 15 | ХӨВСГӨЛ АЛТАН ДУУЛГА     | 13                     | 2,672.00     | 3,050.00   | 378.00                       | 14.15        |
| 16 | МОНИНЖБАР                | 7,425                  | 158.00       | 180.00     | 22.00                        | 13.92        |
| 17 | БАГАНУУР                 | 14,085                 | 1,920.00     | 2,183.00   | 263.00                       | 13.70        |
| 18 | ОЛЛОО                    | 105                    | 75.00        | 85.00      | 10.00                        | 13.33        |
| 19 | ГОВЬ                     | 6,088                  | 13,910.00    | 15,380.00  | 1,470.00                     | 10.57        |
| 20 | БЭРХ УУЛ                 | 295                    | 850.00       | 939.50     | 89.50                        | 10.53        |

## Ханшийн бууралттай хувьцаа

/2017.08.31-ний байдлаар/

| №  | Үнэт цаас нэр     | Арилжигдсан /<br>Ширхэг/ | Хаалтын ханш (₮) |            | Ханшийн<br>өөрчлөлт (₮) | Өөрчлөлт % |
|----|-------------------|--------------------------|------------------|------------|-------------------------|------------|
|    |                   |                          | 2017-8-01        | 2017-08-31 |                         |            |
| 1  | ХЭРЛЭН ХИВС       | 7,202                    | 80.00            | 58.15      | -21.85                  | -27.31     |
| 2  | ХИШИГ УУЛ         | 38                       | 1,400.00         | 1,030.00   | -370.00                 | -26.43     |
| 3  | ГАН ХИЙЦ          | 114                      | 14,500.00        | 12,000.00  | -2,500.00               | -17.24     |
| 4  | ЖЕНКО ТҮР БҮРО    | 186,071                  | 70.00            | 58.65      | -11.35                  | -16.21     |
| 5  | МОННООС           | 127                      | 1,790.00         | 1,500.00   | -290.00                 | -16.20     |
| 6  | УВС ЧАЦАРГАНА     | 70                       | 752.81           | 640.00     | -112.81                 | -14.99     |
| 7  | ДАРХАН ХҮНС       | 5                        | 5,020.00         | 4,270.00   | -750.00                 | -14.94     |
| 8  | ХАЙ БИ ОЙЛ        | 10,094                   | 100.00           | 85.20      | -14.80                  | -14.80     |
| 9  | МОНГОЛ НЭХМЭЛ     | 409                      | 3,740.00         | 3,200.00   | -540.00                 | -14.44     |
| 10 | Э-ТРАНС ЛОЖИСТИКС | 5,401                    | 108.87           | 94.99      | -13.88                  | -12.75     |
| 11 | СОР               | 77                       | 1,130.00         | 999.92     | -130.08                 | -11.51     |
| 12 | БАЯЛАГ НАЛАЙХ     | 1,550                    | 170.00           | 151.00     | -19.00                  | -11.18     |
| 13 | НЭХЭЭСГҮЙ ЭДЛЭЛ   | 211                      | 2,250.00         | 2,000.00   | -250.00                 | -11.11     |
| 14 | РЕМИКОН           | 129,526                  | 44.98            | 41.69      | -3.29                   | -7.31      |
| 15 | ДАРХАН ХӨВӨН      | 1,082                    | 18,000.00        | 17,000.00  | -1,000.00               | -5.56      |



## "ГЕРМЕС ЦЕНТР" ХК НОГДОЛ АШИГ ТАРААХААР БОЛЛОО

"Гермес центр" ХК-ийн ТУЗ-ийн 2017 оны 8-р сарын 02-ны өдрийн №3 тоот тогтоолоор 2017 оны эхний хагас жилийн цэвэр ашгаас нэгж хувьцаандаа 3 төгрөг 81 мөнгө буюу нийт 300 сая төгрөгийг ногдол ашиг болгон хувьцаа эзэмшигчдэдээ хуваарилахаар шийдвэрлэсэн байна.

Энэхүү ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2017 оны 8 сарын 21-ний өдрөөр гаргаж "ҮЦТХТ" ТӨХХК дахь хувьцаа эзэмшигчдийн дансанд 2017 оны 8-р сарын 31-ний өдрөөс эхлэн байршуулахаар болсон байна.

## ГИШҮҮН ҮНЭТ ЦААСНЫ КОМПАНИУДЫН 2017 ОНЫ 2-Р УЛИРЛЫН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ХУРААНГУЙ НИЙТЛЭГДЛЭЭ

"Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-ийн "Гишүүнчлэлийн журам"-ын 4.4.6 болон Гишүүнчлэлийн гэрээний 2.4.6.1-д тус тус зааснаар гишүүн үнэт цаасны компани нь "Нягтлан бодох бүртгэлийн тухай" хуульд заасны дагуу жилийн эцсийн санхүүгийн тайланг аудитын дүгнэлтийн хамт дараа оны 3 дугаар сарын 10-ны дотор, хагас жилийн санхүүгийн тайланг 7 дугаар сарын 25-ны дотор Биржид тус тус ирүүлэх үүрэгтэй байдаг. 2017 оны 2-р улирлын санхүүгийн тайланг нийт 58 гишүүн компаниас 42 компани хугацаанд нь ирүүлсэн байна.

Тайланг хугацаанд компаниудын эргэлтийн хөрөнгө өмнөх оны мөн үетэй харьцуулахад 43 хувиар, богино хугацаат өр төлбөр 83 хувиар, эздийн өмч 10 хувиар, нийт хөрөнгө 23 хувиар тус тус нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

## "СҮҮ" ХК НОГДОЛ АШИГ ТАРААХААР БОЛЛОО

"Сүү" ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2017 оны 8-р сарын 04-ний өдрийн №09 тоот тогтоолоор компанийн нийт хуримтлагдсан ашгаас нэгж хувьцаандаа 10 төгрөг буюу нийт 3.44 тэрбум төгрөгийг ногдол ашиг болгон хувьцаа эзэмшигчдэдээ хуваарилахаар шийдвэрлэсэн байна.

Энэхүү ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтыг 2017 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын бүртгэлийн өдрөөр буюу 2017 оны 4-р сарын 05 -ны өдрөөр гаргах бөгөөд ногдол ашгийг 2017 оны 9-р сарын 04-ний өдрөөс эхлэн "ҮЦТХТ" ТӨХХК дахь хувьцаа эзэмшигчдийн дансанд байршуулахаар болсон байна.

## "ДАРХАН ЗОЧИД БУУДАЛ" ХК-ИЙН ҮНЭТ ЦААСНЫ АРИЛЖААГ ТҮР ЗОГСООЛОО

Санхүүгийн зохицуулах хорооны Улсын байцаагчийн 2017 оны 8 дугаар сарын 29-ний өдрийн 80 тоот албан шаардлагаар ["Дархан зочид буудал" ХК](#)-ийн үнэт цаасны арилжааг 2017 оны 8 дугаар сарын 29-ний өдрөөс эхлэн түр зогсоолоо.





## FTSE RUSSELL КОМПАНИЙН ТАВЬСАН ШААРДЛАГЫГ БИЕЛҮҮЛЭХ ТАЛААР ОРОЛЦОГЧДОД МЭДЭГДЭВ

Монгол Улсын хөрөнгийн зах зээлийг 2012 онд олон улсын индексийн тооцоо, судалгаагаар тэргүүлэгч FTSE Russell компаниас “Хөгжиж буй” /Фронттиер/ зах зээлийн ажиглалтын жагсаалтад оруулснаар манай зах зээл албан ёсны зэрэглэлтэй болох бодит боломж нээгдэж хөрөнгийн зах зээлд ажиллаж буй байгууллагууд болон мэргэжилтнүүд бидний хувьд баярт үйл явдал болж байсан билээ. Гэвч арилжааны төлбөр тооцоо урьдчилсан төлбөрт системээр хийгддэг, “төлбөрийн эсрэг нийлүүлэлт” /DvP/ зарчим хэрэгждэггүй зэрэг шалтгаанаар манай зах зээл өдийг хүртэл албан ёсоор “Хөгжиж буй” зах зээлийн зэрэглэлтэй болж чадаагүй төдийгүй зах зээлд шаардлагатай дэд бүтцийн өөрчлөлтүүд хийгдэхгүй удаашралтай байгаагаас энэ онд ажиглалтын жагсаалтаас хасагдах нөхцөл байдал үүсээд байгаа билээ.

Энэхүү нөхцөл байдлын улмаас “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн ТУЗ-ийн дарга Н.Мандуул болон гүйцэтгэх захирал Х.Алтай нар FTSE Russell компанитай энэ оны 4 дүгээр сард уулзалт зохион байгуулж, төлбөр тооцооны Т+2 горимыг нэвтрүүлэх талаар нэн даруй арга хэмжээ авч ажиллах тул ажиглалтын жагсаалтад хэвээр үлдэх хүсэлт гаргасан билээ. Улмаар зах зээлд оролцогч байгууллагуудаас бүрдсэн ажлын хэсэг байгуулан, холбогдох дүрэм журмуудыг хамтран боловсруулж, ажлын явцыг тухай бүр FTSE Russell компанийн Зах зээлийн ангиллын хорооны гишүүдэд цахим хурал хийж танилцуулан холбогдох бүх арга хэмжээг авч ажиллаж байна.

Ээлжит хурал нь 8 дугаар сарын 8-ны өдөр тохиож ажлын явцыг танилцуулсан бөгөөд төлбөр тооцооны шинэчилсэн дүрэм журмуудыг холбогдох байгууллагуудаар батлуулах ажил нэн даруй хийгдэх шаардлагатай байгааг бусад мэргэжлийн байгууллагуудад мэдэгдэн, даруй арга хэмжээ авч ажиллах хүсэлтийг манай байгууллагаас хүргүүлээд байна. Төлбөр тооцооны шинэчилсэн горимыг нэвтрүүлэх ажлын явц, ахиц дэвшилрийг харгалзан манай зах зээлийг ажиглалтын жагсаалтад үлдэх эсэх нь

энэ оны 9 дүгээр сард болох FTSE Russell компанийн үнэлгээний хурлаар шийдэгдэх юм.

FTSE Russell гэдэг нь олон улсад улс орнуудын хөрөнгийн зах зээлийн зэрэглэл тогтоодог хоёр үндсэн байгууллагын нэг нь бөгөөд “Хөгжиж буй” зах зээлийн зэрэглэлтэй болсноор FTSE Russell индексийг дагаж хөрөнгө оруулдаг 3,5 их наяд ам.долларын хөрөнгө бүхий мэргэжлийн хөрөнгө оруулагчид манай зах зээлд хөрөнгө оруулах алтан боломж нээгдэх ач холбогдолтой юм.

## "ТАЛХ ЧИХЭР" ХК 2017 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ТАЙЛАНГАА ТАНИЛЦУУЛЛАА

Монголын хөрөнгийн биржийн 1-р ангилалд бүртгэлтэй "Талх Чихэр" ХК хагас жилийн санхүү, үйл ажиллагааны тайлангаа Монголын хөрөнгийн бирж дээр 2017 оны 8 дугаар сарын 17-ны өдөр олон нийтэд нээлттэй танилцууллаа.

"Талх Чихэр" ХК нь борлуулалтын 3,000 гаруй цэгтэй бөгөөд хэрэглэгч үйлчлүүлэгчиддээ 20 гаруй нэр төрлийн талх, 30 гаруй нэр төрлийн нарийн боов, 20 гаруй төрлийн бялуу болон бэйкери зэрэг бүтээгдэхүүн үйлдвэрлэж байна. Тус компани нь дэлхийн техник, технологийн дэвшлийг үйлдвэртээ бүрэн хэрэгжүүлэх зорилт тавьж, Олон улсын чанарын удирдлагын тогтолцооны ISO 9001, лабораторийн ISO17025, хүнсний аюулгүй байдлын ISO22000 стандартуудыг хангаж, чанарыг эрхэм болгон ажиллаж байгаагийн зэрэгцээ Монгол улсад цор ганц дэвшилтэт технологи бүхий J4 Давхар шугам, Итали улсын гурилын систем болон силосыг үйлдвэрлэлдээ нэвтрүүлсэн байна.

Санхүүгийн үр дүнгийн хувьд 2017 оны эхний хагас жилд нийт 675.7 сая төгрөгийн цэвэр ашигтай ажилласан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1.4 хувиар өссөн үзүүлэлттэй байна.



## "АПУ" ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН АНХААРАЛД

Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй "АПУ" ХК нь 2017 оны 8 дугаар сарын 18-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаараа "АПУ Дэйри" ХХК оноосон нэр бүхий охин компанийг шинээр үүсгэн байгуулах, "Эвэргрийн инвестмент" ХХК-ийг нэгтгэх замаар компанийн хэлбэрийг өөрчлөн байгуулах, хаалттай хүрээнд 321,304,553 ширхэг энгийн хувьцаа нэмж гарган эзэмшүүлэх, хаалттай хүрээнд нэмж гаргах хувьцаанаас тэргүүн ээлжинд худалдан авах эрхийг эдлүүлэхгүй байх, компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах зэрэг шийдвэрүүдийг тус тус гаргасан байна. Үүнтэй холбогдуулан дээрх шийдвэрүүдийн эсрэг саналтай байсан, эсхүл санал хураалтад оролцоогүй саналын эрхтэй хувьцаа эзэмшигчид Компанийн тухай хуулийн 53 болон 54 дүгээр зүйлд заасны дагуу өөрийн эзэмшлийн хувьцааг эргүүлэн авахыг компаниас шаардах эрх үүссэнийг үүгээр мэдэгдэж байна.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаас шийдвэр гарсан огноо: **2017 оны 8-р сарын 18-ны өдөр**

Хувьцаагаа эргүүлэн худалдан авахыг шаардах эрх дуусах огноо: **2017 оны 9-р сарын 29-ний өдрийг хүртэл**

Шаардах эрхийг хэрэгжүүлэх нэгж хувьцааны үнэ: **360 төгрөг** /сүүлийн 6 сарын жигнэсэн дундаж ханш/

Шаардах эрхээ хэрэгжүүлэх хүсэлтэй бол ["АПУ" ХК](#) болон ["БиДиСек ҮЦК" ХК](#)-д хандана уу.

**Шаардах эрх хэрэгжүүлэгч "АПУ" ХК:** УБ, ХУД 2-р хороо, Чингисийн өргөн чөлөө, компанийн байр, холбогдох утас: 11-344837

**Андеррайтер "БиДиСек ҮЦК" ХК:** УБ, СБД 8-р хороо, Залуучуудын өргөн чөлөө, 27/1 байр, холбогдох утас: 11-313108, 99010288

## "СҮҮ" ХК ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАНГАА ТАНИЛЦУУЛЛАА

Монголын хөрөнгийн биржийн 1-р ангилалд бүртгэлтэй "Сүү" ХК хагас жилийн санхүү, үйл ажиллагааны тайлангаа Монголын хөрөнгийн бирж дээр 2017 оны 8 дугаар сарын 24-ний өдөр олон нийтэд нээлттэй танилцууллаа.

"Сүү" ХК нь 2017 оны 6 дугаар сарын 29-ний өдөр Монголын хөрөнгийн биржээр дамжуулан "Сүү Бонд"-ыг олон нийтэд нээлттэйгээр санал болгон арилжиж, нийт 6 тэрбум төгрөгийн санхүүжилтийг амжилттай татан төвлөрүүлсэн нь дотоодын хөрөнгийн зах зээлд хамгийн өндөр үнийн дүн бүхий өрийн хэрэгсэл гаргасан түүхэн амжилтыг тогтоосон билээ.

Тайлант хугацаанд тус компанийн үйл ажиллагаанд дараах ололт, амжилт гарсан байна. Үүнд:

- Эрүүл мэндийн ач холбогдолтой шинэ бүтээгдэхүүн болох Биофит таргийг худалдаанд гаргав.
- Сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн хэмжээ сүүлийн 11 жил тасралтгүй өсч байгаа бөгөөд тайлант хугацаанд өмнөх оны мөн үеэс 19.4 хувиар өсч 13,500 тоннд хүрсэн байна.
- Борлуулалтын машины тоог нэмэгдүүлснээр хүргэлт, түгээлт сайжирч, хэрэглэгч болон харилцагчийн гомдол 53.9 хувиар буурсан.
- Борлуулалтын орлого өмнөх оны мөн үеэс 10,2 хувиар өсч 24.0 тэрбум төгрөгт, цэвэр ашиг 43 хувиар өсч 2,3 тэрбум төгрөгт тус тус хүрсэн үзүүлэлттэй байна.

"Сүү" ХК нь цаашид Монгол улсын уламжлалт хэрэглээ сүү, сүүн бүтээгдэхүүнийг орчин цагийн хэрэглэгчдийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн үйлдвэрлэн түгээх эрхэм үйлсдээ илүү дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлэн, инновацид тулгуурласан, байгальд орчинд ээлтэй үйл ажиллагаа явуулж, улирал тутамд үйл ажиллагааны болон ашигт ажиллагааныхаа талаар олон нийтэд мэдээлэн ажиллахаа мэдэгдэв.



## “ГОВЬ” ХК ХАГАС ЖИЛИЙН ТАЙЛАНГАА ТАНИЛЦУУЛЛАА

Монголын хөрөнгийн биржийн 1-р ангилалд бүртгэлтэй “Говь” ХК 2017 оны эхний хагас жилийн санхүү, үйл ажиллагааны тайлангаа Монголын хөрөнгийн бирж дээр 2017 оны 8 дугаар сарын 30-ны өдөр олон нийтэд нээлттэй танилцууллаа. “Говь” ХК нь 100% ноолууран пальтоны үйлдвэрлэл болон борлуулалтаараа Дэлхийд №1 болох зорилт тавин ажиллаж байгаа бөгөөд тайлант хугацаанд борлуулалтын орлого нь өмнөх оны мөн үеэс 35 хувиар өсч 33.9 тэрбум төгрөгт, цэвэр ашиг 7 хувиар өсч 3.4 тэрбум төгрөгт тус тус хүрсэн үзүүлэлттэй байна. Тайлант хугацаанд тус компанийн үйл ажиллагаанд дараах онцлох үйл явдлууд гарсан байна. Үүнд:

- Эрээн болон Брюссель хотуудад нэрийн дэлгүүрээ амжилттай нээж, гадаад зах зээлээ тэлэв.
- Өөрийн онлайн худалдааны сайттай ([www.gobicashmere.com](http://www.gobicashmere.com)) болсон бөгөөд дэлхийн хаанаас ч “Говь” брэндийн бүтээгдэхүүнийг худалдан авах боломжтой болов.
- Оёмолын шинэ үйлдвэрийн нээлтээ хийж, оёмолын нийт хоёр үйлдвэртэй болсноор жилд 100,000 ширхэг ноолууран пальто үйлдвэрлэх хүчин чадалтай болов.
- Монгол улсын Ерөнхийлөгчийн тамгын газраас “Үндэсний бүтээн байгуулалтын дээд шагнал-Төрийн гэрэг” шагналыг хүртэв.
- 6 сарын 14-ний өдөр үйлдвэрийн дээвэрт гүйцэтгэгч компани нөхөн засварын ажил хийх явцад гэнэтийн галын аюул тохиолдсон ч, ОБЕГ, УСУГ зэрэг ЗГ-ын харьяа байгууллагууд, харилцагч, хамтран ажиллагч байгууллагууд болон нийт ажилтнуудынхаа хамтын хүчээр арван хоногийн дотор буюу 6-р сарын 24-нд үйлдвэрийн хэвийн үйл ажиллагаагаа эхлүүлж чадсан байна.

“Говь” ХК нь цаашид гадаад зах зээл дээрх “Говь” брэндийн нэрийн дэлгүүр болон франчайзингийн стратегийг газар зүйн бүс болон зах зээл бүрийн онцлогт тохируулан боловсруулан хэрэгжүүлж, 2021 он гэхэд гадаад

зах зээл дэх дэлгүүрийн тоог 100-д хүргэж, өөрийн нэрийн 20 дэлгүүртэй болохыг зорин ажиллаж байгаа бөгөөд хувьцаа эзэмшигч нартаа хандан компанийнхаа үйл ажиллагааны талаар үнэн бодит мэдээллийг цаг алдалгүй түгээж, мэдээллийн ил тод байдлыг ханган ажиллахаа мэдэгдэв.

## “АПУ” ХК ХАГАС ЖИЛИЙН ТАЙЛАНГАА ТАНИЛЦУУЛЛАА

Монголын хөрөнгийн биржийн 1-р ангилалд бүртгэлтэй “АПУ” ХК хагас жилийн санхүү, үйл ажиллагааны тайлангаа Монголын хөрөнгийн бирж дээр 2017 оны 8 дугаар сарын 30-ны өдөр олон нийтэд нээлттэй танилцууллаа.

2017 оны эхний хагас жилд “АПУ” ХК нь дараах голлох үр дүнгүүдийг гаргасан байна. Үүнд:

- Цэвэр борлуулалтын орлого өмнөх оны мөн үетэй харьцуулахад 12%-иар өсч, 108.4 тэрбум төгрөгт хүрсэн;
- Цэвэр ашиг 15.9 тэрбум төгрөг буюу өмнөх оны мөн үетэй харьцуулахад 63%-ийн өсөлтийг үзүүлсэн;
- Хагас жилийн хугацаанд улсын төсөвт нийт 60.8 тэрбум төгрөгийн татварыг төлөв;
- Тайлант хугацаанд нийт 7.9 сая ам.доллар буюу 19.1 тэрбум төгрөгийн зээлийг төлж барагдуулсан бөгөөд оны сүүлийн хагас жилд мөн дүнтэй зээлийг төлөх төлөвлөгөөтэй ажиллаж байна.
- “АПУ” ХК нь 2017 оны 8 дугаар сарын 18-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаараа “АПУ Дэйри” ХХК оноосон нэр бүхий охин компанийг шинээр үүсгэн байгуулах, “Эвэргрийн Инвэстмэнтс” ХХК-ийг нэгтгэх замаар компанийн хэлбэрийг өөрчлөн байгуулах, хаалттай хүрээнд 321,304,553 ширхэг энгийн хувьцаа нэмж гарган эзэмшүүлэх зэрэг шийдвэрүүдийг гаргасан.

Тус компани нь цаашид шинийг эрэлхийлж, амжилтаа ахиулан, тогтвортой өсөлтийг бий болгохын төлөө ажиллахын зэрэгцээ мэдээллийн ил тод байдлыг улам сайжруулж, шинэ жишиг тогтоон ажиллахаа мэдэгдэв.





## “МИК ХОЛДИНГ” ХК ХАГАС ЖИЛИЙН ТАЙЛАНГАА ТАНИЛЦУУЛЛАА

Монголын хөрөнгийн биржийн 1-р ангилалд бүртгэлтэй "Мик Холдинг" ХК хагас жилийн санхүү, үйл ажиллагааны тайлангаа Монголын хөрөнгийн бирж дээр 2017 оны 8 дугаар сарын 25-ны өдөр олон нийтэд нээлттэй танилцууллаа.

Монголын ипотекийн хоёрдогч зах зээлийг хөгжүүлэх зорилго бүхий байгууллага болох “МИК ОССК” нь 2006 онд Монголбанк болон арилжааны 10 банкны төлөөлөл бүхий Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрээр үүсгэн байгуулагдсан бөгөөд 2015 онд “МИК ОССК” ХХК-ийн нийт хувьцаа эзэмшигчдийн эзэмшиж буй хувьцааг “МИК Холдинг” ХК-ийн хувьцаагаар солих замаар “МИК Холдинг” ХК-ийг “МИК ОССК” ХХК-ийн толгой компани болгон бүтцийг өөрчилж, Монголын Хөрөнгийн Биржид бүртгэлтэй олон нийтэд нээлттэй хувьцаат компани болсон билээ.

2017 оны 2-р улирлын байдлаар тус компанийн худалдан авсан буцаах нөхцөлтэй ипотекийн хөрөнгийн багц 33.8 тэрбум төгрөг, 8% болон 5%-ийн хүүтэй ипотекийн зээлийн багцыг худалдан авч, ипотекийн зээлээр баталгаажсан

үнэт цаас гаргасан хэмжээ 2,451.7 тэрбум төгрөгөөр тус тус хэмжигдэж байгаа бол өөрийн хөрөнгийн дүн өнгөрсөн оны мөн үеэс 12.7 хувиар өсч, 160.4 тэрбум төгрөгт, цэвэр ашгийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 18 хувиар өсч, 36.1 тэрбум төгрөгт тус тус хүрсэн байна.

Тус компани нь 2017 онд мэдээллийн аюулгүй байдлын удирдлагын тогтолцооны ISO 27001:2013 стандартыг хэрэгжүүлж, гэрчилгээ авсан бөгөөд цаашид орон сууц эзэмшигчдийг нэмэгдүүлэхэд дэмжлэг болохуйц тогтвортой бизнес загвар бүхий олон улсын жишигт нийцсэн байгууллага болох, хямд санхүүжилтийн эх үүсвэрийг дотоод, гадаад зах зээлээс эрэлхийлж багцын худалдан авалтын төрөл, хэмжээг нэмэгдүүлэх, шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ гаргах боломжуудыг судлах, төрөөс хэрэгжүүлж буй одоогийн ипотекийн санхүүжилтийн хөтөлбөр, төслүүдэд үргэлжлүүлэн идэвхтэй хамтран ажиллаж нийт 1 их наяд төгрөгийн ипотекийн хөрөнгө худалдан авч, 0.9 их наяд төгрөгийн ипотекийн зээлээр баталгаажсан үнэт цаас гаргах зэрэг зорилтууд тавин ажиллахаа мэдэгдэв.

# МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН

---



Монгол Улс, Улаанбаатар  
хот 15160

Чингис Хааны талбай-3

Монголын Хөрөнгийн Бирж



+976 11-313747



+976 11-325170



Info@mse.mn



WWW.MSE.MN